

АРХЕОЛОГИ

ХАР ХОРУМЫН ШААЗАН ЭДЛЭЛИЙН ХОЁР ДАРШИЙГ СУДАЛСАН ТУХАЙ

У.ЭРДЭНЭБАТ
ШУА-ийн Түүхийн хүрээлэн

Археологийн олдворын нэгэн төрөл зүйл бол эрт цагт амьдарч байсан хүмүүсийн эх дэлхийн хөрсөнд булж далдалсан хийгээд олж авахад амаргүй газар нууж дарсан элдэв эдийн боловсролын дурсгалт зүйлсийн дарш билээ. Хээрийн шинжилгээний явцад суурин амьдралын ул мөрийг хадгалсан археологийн дурсгал бүхий газраас үнэт металл болон төмөрлөг боловсруулах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, алт, мөнгө, хүрэл зоос, шил шаазан, яс, мод, үнэт чулуугаар урлаж хийсэн эдлэл зэрэг эрдэнэс баялагийн үлдэц илэрч олдох нь багагүй.

Эртний хүмүүсийн гараар тодорхой орон зай, цаг хугацаанд ямар нэг зорилгын үүднээс ийнхүү бусдаас нууж далдалсан хөрөнгө зоорь, бараа бүтээгдэхүүний агуулахаас эхлээд үйлдвэрлэлийн гологдол, хог хаягдал нь хүртэл түүхийн шинжлэх ухаанд судалгааны үнэт баримт болох бөгөөд ийм олдворын холбогдох он цаг, угсаа соёлын хүрээ хамаадлыг тодорхойлох нь чухал ач холбогдолтой. Түүгээр ч барахгүй зарим тохиолдолд, археологийн малтлагаар илрүүлж олсон олдворууд буюу эд өлгийн биет дурсгал нь бичгийн сурвалжид тэр бүр тэмдэглэгдээгүй, тэмдэглэгдсэн ч бидний үеийг хүртэл уламжлагдан ирж чадаагүй түүхэн тодорхой үеийн хүмүүсийн аж ахуй, соёл, зан заншил, нийгмийн харилцааны хөгжлийг тодруулан шинжлэх цорын ганц найдвартай хэрэглэгдэхүүн болдог юм.

Монголын хот сууриныг урьд өмнө археологийн талаар шинжлэн судлах явцад эртний хотын оршин суугчдын булж далдалсан элдэв эдлэл хэрэглэлийн даршны үлдэц нэг бус удаа янз бүрийн байдлаар илрэн олдож байжээ¹. Үүний дотор манай орны нутаг дэвсгэрт буй эртний хот балгасын ор үлдцээс хамгийн арвин олддог, статистикийн хувьд бусад төрлийн жижиг олдворуудтай харьцуулж үзвэл тоо хэмжээ болоод нэр төрлийн хувьд үлэмжхэн хувийг эзлэх ваар, шаазан эдлэл нэн сонирхолтой.

Бид энэхүү өгүүлэлдээ манай өвөг дээдсийн бүтээн байгуулсан хот суурины дотроос дэлхий дахины эрдэмтэн судлаач нарын анхаарлыг хамгийн ихээр татсан хотын нэг гэж хэлж болох Их Монгол Улсын нийслэл Хар Хорум балгасын дэвсгэрээс илэрсэн шаазан эдлэлийн хоёр даршийг судалсан тухайгаа танилцуулъя.

1978 онд олдсон шаазан эдлэлийн дарш

1976-1985 онд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс эрхлэн их гүрний нийслэл Хар Хорум хотыг археологийн талаар шинжлэн судлах ажлыг үргэлжлүүлсэн бөгөөд тус хээрийн шинжилгээний анги хотын газрын гадаргын хотгор гүдгэрийг дүрсэлсэн зураглал үйлдэн талбайн хэмжээг тогтоож, зарим барилгын үлдэгдэл дээр бага хэмжээний малталт хийж, соёлт давхаргыг тодорхойлон, түүвэр олдвор цуглуулж бүртгэн, эрдэм шинжилгээний

¹ Д.Наваан. Клад железных предметов из Хара-Хорина. Монгольский Археологический Сборник. Издательство АН СССР., М., 1962, стр. 62-63

боловсруулалт хийж манай эх орны дундад зууны үеийн түүхийг судлах шинэ сонин эх хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж билээ.

Монголын археологич, доктор Н.Сэр-Оджав, Д.Баяр нарын удирдсан энэхүү хээрийн шинжилгээний ангийн 1979 оны хээрийн судалгааны явцад эртний хотын дэвсгэрээс нутгийн оршин суугчид шаазан эдлэлийн нэгэн даршийг санамсаргүй байдлаар илрүүлэн олсон тухай мэдээ судлаачдын сонорт хүрчээ². Энэхүү мэдээллийн мөрөөр мөшгин үзвэл, 1978 оны намар Өвөрхангай аймгийн Хар Хорин суман дахь Хорих газраас эрхлэн эртний хотын дэвсгэрт тахианы фермийн өргөтгөл барихад зориулан барилгын суурь ухаж байх үед нилээд олдворын зүйлс, хүний яс зэрэг юмс олдсон гэх сураг дуулдсан байна. Үүний дагуу судлаачид газар дээр нь шалган үзэж тус байгууллагын удирдах нөхөдтэй уулзаж ярилцвал Хорихын улс төрийн орлогч, дэд хурандаа С.Цэен-Ойдов, уг олдворын зүйлсийг тэндхийн складад бөөнөөр авч хадгалсан байснаа археологичдод хүлээлгэн өгч үнэтэй туслалцаа үзүүлжээ.

Археологичид барилгын ажил явагдсан газраар хайгуул хийж сайтар шалгасны дүнд хоёр хүний гавлын яс, мөн эндээс нилээд зайтай Өгэдэй хааны ордны хавь газраас бас нэгэн гавлын яс олсон нь бүгд нэг дороос олдоод хожим тарж сарнисан бололтой байжээ. Хорихын удирдах нөхдөөс олдворын зүйлс хүлээн авсны дараа уг газраар дахин шалгалт хайгуул явуулж, дундад зууны Хар Хорум хотын үед холбогдох шаазан шавар савны үлдэгдэл нилээд хэмжээтэй цуглуулсан байна.

Эдгээр шаазан, шавар савны холбогдолтой олдворууд эдүгээ Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Археологийн сан хөмрөгт хадгалагдаж байна. Үүнээс Хар Хорум хотын турийн хойд хэсэгт бариулсан фермийн барилгын өргөтгөлийн үеэр 1978 оны намар нэг дороос бөөнөөр олдсон шаазан эдлэл, сав суулгын зүйлсийг тодорхойлон бичвэл:

1. Ургамал болон амьтны дүрст хээтэй том таваг, өрөөсөн талын ирмэг хэсэг бага зэрэг хагарснаас биш бараг бүтнээрээ маш сайн хадгалагдаж үлджээ (1-р зураг). Хар Хорум хотыг урьд өмнө малтан шинжилж байсан судалгаанаас иймэрхүү төрлийн будаг хээтэй аяга сав олдож байснаас бус ийм үзэсгэлэнтэй сайхан хээтэй том таваг бүтнээр олдож байсан удаагүй юм. Цагаан өнгийн дэвсгэр дээр хар хөх өнгийн будгаар янз бүрийн ургамлын дүрст хээ, амьтны дүрс урлан зуржээ. Тавагны дотор талд, гол дунд нь алхаж буй өрөвтас шувуу, үүний дээр дор нь нижгээд том цэцэг, баруун зүүн хоёр талд нь усанд хөвж буй галуу, нугас дүрсэлсэн байх ба бусад хэсгээр элдэв янзын цэцэг навчсын зураг дүрсэлжээ. Тавагны дотор талын ёроолын ирмэгээр энэхүү төв хэсгийг заагласан дөрвөн нарийхан зураас тойроглон зурсан байх ба үүнээс дээш савны ханын хэсгийг чимэглэсэн цэцэг, навчин хээ үргэлжилж, дээд талаар нь амсрыг дагуулан нэг нарийхан зураасаар төгсгөсөн байна. Савны гадна талын ханыг дотроо үүлэн хээтэй, бадамлянхуа цэцгийн дэлбээ мэт хээгээр чимэглэсэн байна. Уг тавагны ёроол хэсгийг пааландалгүй үлдээсэн бөгөөд ямар нэг тамга тэмдэг, дүрс үсгийн ором байхгүй юм.

Хэмжээ: амсар хэсгээрээ 29 см, ёроолоор 21 см, өндөр нь 4 см болно. Энэ таваг бол хятадын алдарт чен-хуа хэмээх хөх хуартай шаазан мөн.

2. Ногоон өнгийн паалантай том селадон таваг (2-р зураг). Селадон хэмээх ерөнхий нэрээр нэрлэгдсэн ийм төрлийн шаазан савны үлдэгдэл Хар Хорум хотоос нилээд хэмжээтэй олддог юм. Гэхдээ ийм том таваг бараг бүтнээрээ ингэж сайн хадгалагдаж үлдсэн нь урьд өмнө тохиолдоогүй. Үүнийг эвлүүлж наахад хажуу бөөр ба амсрын өчүүхэн хэсгээс бусад нь бүрэн байлаа. Бүдэг ногоон өнгийн паалантай

² Н.Сэр-Оджав, Д.Баяр. Хар Хорумын шинжилгээний ангийн 1979-1980 оны ажлын тайлан. УБ., 1981, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг

гадагш дэрвийсэн амсартай ба амсар нь долгион хэлбэртэй. Паалангийн доогуур зурж гаргасан хэсэгт хээ нь товгор байна. Тавагны голд товойлгож гаргасан цэцгэн хээтэй ба үүнийг тойрсон дугуй хүрээнээс дээших ханын хэсгээр босоо шулуун зураас хонхойлгож гаргаад, амсрыг гадагш эргүүлж, ирмэгийг нь долгио маягтай хийжээ. Амсрын гадна талын ханыг хүрээлсэн шулуун зураас хээнээс доош шаазангийн их биеийн гүдгэр хэвийг даган паалангийн будаг хонхор хэсэгт нь тунарч ороод босоо шулуун зураас үүсгэсэн үзэгдэнэ. Хэмжээ нь: амсраар 27 см, ёроол нь 10,7 см, өндөр нь 5,7 см байна.

Энэ таваг голоороо шулуун хагарч 2 том хэсэг болсон нь их дээр үеийн хагарал бололтой бөгөөд ханын гадна талд энэхүү том хагарлыг нийлүүлэн төмрөөр баривч хадан хэрэглэж байсны ором хадаасны 4 нүх байна.

Уг таваг нь селадоны ангид багтдаг лунцюань төрлийн шаазан мөн. Хар Хорумаас олдож буй энэ төрлийн шаазан ихэвчлэн ногоон өнгөтэй ба паалан нь жигд бөгөөд зузаавтар байдаг. Голыг нь цайвар шороог сайтар нунтаглаж зуураад дутуу шатаасны дараа их биен дээр нь хулсан үзгээр хээ тавьж пааландсан учраас тэр хээний дагуу будаг нь урсаж ороод гүн ногоон болж харагдана. Өндөр хэмд шатаах тул гол нь нягт бөгөөд бат бөх байдаг.

3. Ногоон паалантай том селадон аяга (3-р зураг). Энэхүү шаазан нь мөн хятадын лунцюань хэмээх төрөлд багтана. Үүнийг эвлүүлж наахад хана ба амсар хэсгийн зарим хагархайнуудаас бусад нь бүрэн эвлэрч бараг бүтэн болсон байна. Амсраараа ялихгүй гадагш эргэсэн, цөгцөн ёроолтой, бөөрөнхий бөөртэй том аяга юм. Амсрын ирмэг нь долгион хэлбэртэй, голдоо пүүзэн хээтэй ба үүнээс дээш бөөр хэсгээр ургамлын хэлбэрт угалз хээтэй, түүний дээгүүр 2 давхар долгиолсон хээгээр эмжжээ. Гадна талын ханаар мөн хэв гаргаж урласан босоо шулуун хээтэй. Шаазангийн гадна талын бөөрцөгний хээ тод ногоон өнгөтэй бөгөөд харин дотор талын пүүзэн хээнээс бусдыг цайвар өнгөөр дүрсэлжээ. Амсрын хэмжээ: 20 см, ёроолын хэмжээ 7 см, өндөр 6 см байна.

4-6. Ногоон паалантай жижиг селадон таваг (4-р зураг). Эртний хятадын рү хэмээх шаазангийн төрөлд хамаарагдах, хэмжээ хэлбэрээр ижил гурван таваг олдсон байна. Амсар ба ханын хэсэгт бага зэрэг дутуугаас биш бараг бүтнээр эвлэрсэн юм. Эдгээрийн хоёр нь арай цайвар ногоон өнгөтэй, голдоо тод ногооноор гаргасан навчин хээтэй ёроолын дотор талыг дугуй гортиг зураасаар ялгасан байна. Ёроолдоо хар өнгийн будаг буюу бэхээр ямар нэгэн үсэг зурсан бололтой. Нэгийнх нь нилээд тод, нөгөөгийнх нь бүдгэрч бараг арилжээ. Гурав дахь нь арай бараавтар ногоон өнгөтэй, дотор талын хээ нь ижил боловч голын навчин хээ бүдгэрч бараг мэдэгдэхгүй болжээ. Ёроолд нь мөн ямар нэг үсэг байсан бололтой хар будгийн ором байна. Аль аль нь гадна талдаа амсрын доогуур гаргасан шулуун зурааснаас өөр хээ угалз байхгүй. Эдгээрийн хэмжээ амсраар 18,5 см, ёроол нь 9 см, өндөр нь 3 см болно.

1999 онд илэрсэн шаазан эдлэлийн дарш

Монгол Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын хооронд шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах тухай байгуулсан хэлэлцээрийн дагуу 1999 оноос эхлэн Монголын эртний нийслэл Хар Хорум хотыг археологийн талаар шинжлэн судлах хоёр улсын эрдэмтдийн хамтарсан төсөл амжилттай хэрэгжиж байгаа билээ³.

³ K.Sagaster. Die mongolische Hauptstadt Karakorum. Beitrage zur allgemeinen und vergleichende Archäologie. Band 19, 1999, S. 113-128; H.-G.Hüttel. Das Zerbrochene bergen. Die Mongolisch-Deutsche Karakorum-Expedition. Mongolische Notizen. Band 9, 2000, S.40-44

Уг төслийн эрдэм шинжилгээний ажилд Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэн, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Археологийн Хүрээлэнгийн Ерөнхий ба Харьцуулсан Археологийн Комисс, Бонны Райны Фридрих Вильхельмийн Их Сургуулийн Өвөг ба Эртний Түүхийн Археологийн хүрээлэн оролцож байна. Монгол-Германы Хар Хорум Экспедицийн 1999 оны археологийн хээрийн шинжилгээ нь тус хотын ерөнхий байрлал, газрын хөрсний үе давхрагын онцлог, өмнөх судалгааны байдал төлөвийг тандан мэдэж цаашдын үйл ажиллагааны чиг хандлагаа тогтооход чиглэгдсэн юм⁴.

Энэхүү хамтарсан судалгааны явцад Хар Хорум хотын турийн төв хэсэгт байгаа хоёр гудамжны уулзварт орших гар урчууд, худалдаачдын хороолол байсан бөгөөд 1948-1949 онд Зөвлөлт Холбоот Улсын Шинжлэх Ухааны Академи, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн хамтарсан "Монголын түүх, угсаатны зүйн экспедицийн" археологийн малталт хийсэн газарт явуулсан туршилтын малтлага шинжилгээний үеэр өмнөх судалгааны явцад хөндөгдөөгүй бололтой хэсэг шаазан эдлэлийн дарш үлдэгдлийг С.В.Киселевын ерөнхий удирдлагын дор явуулсан хуучин малталтын нүхний төв хэсэгт, тухайн үед булагдсан хөрснөөс доош 1,68 метр гүнд илрүүлэн олсон юм. Монгол, Германы эрдэмтдийн хийсэн зүсэлтийн зургаас үзэхэд эдгээр шаазан сав суулганы зүйлсийг энд зориуд тусгай нүх ухаж булсан болох нь тогтоогдсон бөгөөд улмаар малтлагын гүн 2 м хүрэхэд эх газрын ул хөрсөнд тулсан билээ. Мөн энэхүү шаазангийн үлдэгдэл бүхий нүхнээс байгалийн шинжлэх ухааны аргаар хөрсний соёлт давхрагын он цагийг тодорхойлж болох материал олдсон нь Хар Хорум хотын археологийн үечлэлийг тогтооход чухал ач холбогдолтой болсныг зориуд тэмдэглүүштэй.

Хар Хорум хотын гудамжны уулзварын барилгын малталтаас гарсан эдүгээ Монгол улсын ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн Археологийн сан хөмрөгт хадгалагдаж буй шаазан сав суулганы зүйлсийг тодорхойлон бичвэл:

1. Цагаан өнгийн паалантай, дотор талдаа улаан будгаар хос загасны дүрс зурсан таваг (5-р зураг). Үүний ёроол бүтэн. Харин амсар хийгээд бөөрцөг зарим хэсгээр дутуу байна. Тавагны гадна талын бөөрцөгний хормой ба ёроолыг пааландалгүй дутуу орхисон бөгөөд энэ хэсэгт ямар нэг зураг чимэглэлгүй. Харин тавагны дотор талд шаазангийн амсрыг тойруулан улаан өнгийн будгаар гурван эгнээ зурвас тойрог дүрсэлсний голынх нь өргөн бөгөөд дундаа зургаан ширхэг ногоон өнгийн зууван дүрстэй. Тавагны дотор талд тойргийн төв дунд хос загасыг хооронд нь зөрөлдүүлэн дүрсэлжээ. Загасны их биеийг улаан өнгийн зураасаар гаргаж урлахдаа түүний бүлтгэр нүд, сэлүүр, хайрс тэргүүтнийг тод томруун үзүүлсэн байна. Мөн загасны сэлүүр ба сүүлний завсар зайд ногоон өнгийн будгаар ямар нэгэн замаг бололтой ургамал дүрсэлжээ. Энэхүү таваг нь юли-хун хэмээх төрөлд багтах улаан будагтай шаазан мөн. Хэмжээ: Амсрын хэсэг сэргээсэн байдлаар 16,5 см. Ёроол 6,4 см. Өндөр 3,9 см.

2. Ногоон паалантай цом-хундага маягийн селадон сав (6-р зураг). Гадагшаа үл мэдэг дэрэвгэр амсартай өндөр суурьтай уг цомын нэг талын бөөрцөгний хэсэг олноогүй боловч бүх талын хэмжээг сэргээн мэдэж болно. Уг хундаганы гадна талын хананд амсрыг тойруулан дөрвөн эгнээ нарийн зурвас хүрээлж, дээд талын хоёроос гурван зурвасыг хөндлөн огтолсон гурав гурван богино хэрчлээсийг савны амсрыг

⁴ Д.Баяр, У.Эрдэнэбат. Монгол-Германы Хар Хорум Экспедицийн 1999 оны тайлан. УБ., 1999, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн сан хөмрөг

1948-1949 онд Хар Хорум хотын гудамжны уулзварын барилгад явуулсан малтлагын хэмжээ нь, уг шинжилгээний ангийн бүтээлд хавсаргасан дэвсгэр зургаас үзэхэд 34х22 м хэмжээтэй байсан бөгөөд соёлт давхрагын зузаан 5 м хүрч байсан гэж тэмдэглэсэн байдаг.

тойруулан хооронд нь зайтай дүрсэлжээ. Мөн савны өндөр бариулын хүрээг тойруулан хоёр эгнээ нарийн зурвас хүрээлж түүнийг тойруулан бөөрцөгний хэсгийг гурван эгнээ хагас дугуйрсан зураасуудаар чимэглэсэн байна.

Цомын дотор талд ёроол хэсгийн суурьтай нийлсэн заагийг нижгээд нарийн зураасаар тодруулж, голын нь тойрог дотор гурван дэлбээтэй цэцэг навч дүрсэлсэн нь нилээд бүдгэрсэн үзэгдэнэ. Цомын дотор талд буй энэ зурвас хүрээнээс дээш амсар хүртэлх зайг нэг нэг зураасаас бүрдсэн дугуйрсан маягийн хээ угалзаар чимэглэжээ.

Эдгээр хуар чимэглэлийг уг шаазанг пааландахаас өмнө их биен дээр нь хулан үзгээр зурж чимэглээд дараа нь бүдэг ногоон өнгийн паалан гүйлгэжээ. Иймээс будаг нь зурсан хэсэгт урсаж ороод бусдаас илүү тод бараан өнгөтэй үзэгдэнэ. Түүнчлэн уг цомын ёроолд шаазанг элс дэвсэн шатааж байсны ул мөр болох шатаж түлэгдсэн элсний ором, паалангийн хөөстэй холилдож шаргалтан харагдана. Цомын суурийн ёроол дотогшоо хонхорхой бөгөөд ямар нэг дүрс чимэглэл байхгүй. Энэхүү савны хийц, загварын онцлогоос үзэхэд хятадын рү хэмээх шаазангийн төрөлд хамаарах нь эргэлзээгүй. Хэмжээ: амсар 11,5 см, ёроол 3,9 см, өндөр 7,6 см, бариул буюу суурийн өндөр 4,4 см байна.

3. Цэгээн өнгийн гялалзсан паалан гүйлгэсэн, долгио маягийн дэрэвгэр амсартай, тэгш ёроолтой жижиг шаазан аяга (7-р зураг). Үүний амсар, бөөрцөгний зарим хэсэг дутуу боловч ерөнхий хэлбэр төрхийг сэргээж болно. Энэ аяганд тусгайлан зурсан чимэглэл үгүй боловч анх үйлдэхдээ түүний нимгэн амсрыг цэцгийн дэлбээ мэт долгиотсон хэлбэртэй болгох гэж шаазангийн их биеийг тусгай хэвээр байлгасан бололтой. Хэмжээ: амсраар 12 см, ёроол 4,1 см, өндөр 3,6 см болно. Үзээд байхад энэ аяга эртний хятадын ин-тин хэмээх шаазангийн төрөлд хамаарах бололтой.

4. Хөх өнгийн паалантай селадон таваг (8-р зураг). Энэ бол <<Монголын Нууц Товчоо>>-ны 179 дүгээр зүйлд нэр дурдагддаг, өдгөө ч Хар Хорум хотын туриас элбэг олддог цзюнь хэмээх төрлийн шаазан мөн. Уг тавгийг эвлүүлж наахад бараг бүтэн болсон бөгөөд амсрын орчим өчүүхэн хэсэг дутсан. Хөх өнгийн гоёмсог паалан нь тавагуудаа олон цэг торлол бүхий хөөстэй. Бөөрцөгнөөс доошхи ёроолын хэсгийг пааландалгүй орхисон бөгөөд ямар нэг зураг, чимэглэл байхгүй юм. Хэмжээ: Амсар 17 см, ёроол 5,6 см, өндөр 3 см байна.

5. Цагаан шаргал өнгийн паалантай бүтэн аяга (9-р зураг). Том амсартай, ямар нэг зураг чимэглэлгүй, бөөрцөгнөөс доошхи хэсгийг пааландалгүй орхисон. Аяганы дотор талд уг шаазанг угсран шатааж байсны ором болох 7-8 ширхэг паалангүй жижиг хэсэг үзэгдэнэ. Хятадын дин хэмээх шаазангийн төрөлд багтах ийм хэлбэрийн сав сууртын үлдэгдэл Хар Хорум хотын туриас элбэг олддог бөгөөд үүнийг хотын хүн ам ардэн хэрэглэж байжээ. Хэмжээ: Амсар 22 см, ёроол 8,5 см. Өндөр 8 см. Аяганы ёроолд зориуд гаргасан бололтой 0,5 см голчтой нэвт нүх бий. Энэ нь шаазангийн болцыг шалгах гэж зуухан дотор нь хурц үзүүртэй төмөр буюу хулсаар хатгаж үздэг байсны ул мөр болно.

6. Цагаан паалантай, хар хүрэн будгаар зурсан хуартай шаазан аяга (10-р зураг). Үүний амсрын хэсэг багахан дутуугаас биш бараг бүтэн шахуу сайн хадгалагджээ. Аяганы дотор талын амсар болон ёроолын ханыг дагуулан тус бүр нэг эгнээ хэдэн өнгөтэй зурвас тойрог хүрээлж түүний хооронд гурван хэсэг газар хар будгаар ургамлын навч бололтой ижилхэн хуар дүрсэлжээ. Мөн аяганы дотор талын ёроолд уг шаазанг угсран шатааж байсны ором болох паалан нь ховхорсон зууван хэлбэртэй 8 хэсэг газар бий. Энэхүү шаазан аяганы зөвхөн дотор тал хуар зурагтай өнгөнд түүний гадна талын бөөрцөгнөөс доошхи хэсгийг пааландалгүй орхижээ. Энэ нь зарим газар зузаан, зарим газар нимгэн, жигд бус гүйлгэсний зэрэгцээ

аяганы их биеийг эргэх хүрдэн дээр зорж хийсэн ором тодорхой харагдана. Энэ аяга бол мөн хятад шаазангийн дин хэмээх төрөлд хамаарна. Хэмжээ: амсар 19 см, ёроол 8 см, өндөр 6 см байна.

7. Цагаан паалантай сав (11-р зураг). Энэхүү шаазангийн хагархайг цуглуулж лабораторид эвлүүлж наахад амсар болон бөөрцөгний хэсэгт өчүүхэн газар дутсанаас биш бараг бүтэн болсон юм. Богино хүзүүтэй, яльгүй дэрэвгэр амсартай, бага зэрэг цүлхэн бөөртэй савны хүзүүнд их биен дээр нь нааж хийсэн хоёр жижиг бариулын ором буй. Савны гадна дотно талд ямар нэг хуар чимэглэл байхгүй. Дотор талыг бүхэлд нь пааландсан бөгөөд ёроолд нь гурван хэсэг газар наалдсан жижиг шавар бий. Харин савны гадна талыг бөөрцөгнөөс доош пааландалгүй үлдээсэн байна. Шаргал туяатай цагаан пааланг жигд гүйлгэсэн бөгөөд нарийн ажиглавал дээр нь хар цэг толбо үзэгдэнэ. Энэ сав бүхий л шинж байдлаараа дин хэмээх төрөлд багтах нь эргэлзээгүй байна. Хэмжээ: амсар 12,6 см, өндөр 12,2 см, ёроол 7,2 см болно.

8. Ногоон паалантай бүтэн селадон аяга (12-р зураг). Хятад шаазангийн рү хэмээх ангилалд багтана. Гялалзсан тод ногоон өнгөтэй. Гадна дотно талдаа шаазанг пааландахын өмнө их биен дээр нь хулсан үзгээр зурсан хээ хуартай. Тухайлбал, дотор талын хананд эрчилсэн зураасаар угалз гаргаж, ёроолд нь хоёр эгнээ зурвас тойрог хүрээлжээ. Үүний голд ямар нэг хээ байвч ихэд бүдгэрэн бараг мэдэгдэхгүй болжээ. Аяганы амсрыг дагуулан гадна талын ханыг 3 зэрэгцээ зураасаар хүрээлж, зарим газар түүнийг хөндлөн огтолсон 3 зэрэгцээ хэрчлээс дүрсэлсэн нь өмнө тодорхойлсон рү төрлийн цом хэлбэрт шаазан хундаганыхтай ижил байна. Энэ шаазангийн их биеийг шатааж пааландахаас өмнө амсрын хэсэгт дарж шалчийсан хонхор бий. Ёроолыг хүрэн будгаар будаж аяганы бөөрцгийг тойруулан цэцгийн таван дэлбээ мэт хос зураасуудаар чимжээ. Хэмжээ: амсар 16,2 см, өндөр 6,6 см, ёроол 6,3 см болно.

9. Цагаан паалантай жижиг сав (13-р зураг). Хагархайг нь эвлүүлж наахад бүрэн бүтэн сав болсон. Дин хэмээх төрөлд багтах энэхүү сав богинохон хүзүүтэй, яльгүй дэрэвгэр амсартай, цүлхэгэр бөөртэй. Савны хүзүүнд их биен дээр нь нааж хийсэн хоёр бяцхан сэнж бий. Савны дотор талыг бүхэлд нь пааландсан бөгөөд ёроолд нь 3 хэсэг газар наалдсан бяцхан шавар харагдана. Энэхүү савны гадна талыг пааландахдаа бөөрцөгний өчүүхэн хэсэг болон ёроолын нь талыг дутуу үлдээсэн байна. Пааланг жигд бус гүйлгэсэн тул зузаан газраа урсаж ирээд тунарсан харагдана. Энэ саванд ямар нэг зураг чимэглэл байхгүй. Хэмжээ: амсар 9,3 см, өндөр 9,3 см, ёроол 6,6 см болно.

10. Цагаан өнгийн пял таваг (14-р зураг). Дин хэмээх төрөлд багтах зузаан амсартай уг шаазан таваг голоороо хоёр хуваагдан хагарсныг эвлүүлж наасан. Шаазангийн их биенд пааландахын өмнө санамсаргүй дарж шалчийлгасан ором байхын зэрэгцээ бас амсар нь нэг газраа эмтэрсэн нь их дээр үеийнх бололтой. Шаазангийн пааланг жигд бус түрхсэний дээр, тавагны гадна талын бөөрцөгнөөс доошхи хэсгийг пааландалгүй үлдээсэн байна. Тавагны дотор талд хүрэн будгаар хуар навч дүрсэлсэн бөгөөд голд нь дөрвөн хэсэг газар наалдсан шавар буй. Энэ нь уг дийзийг олноор нь давхарлаж угсран шатааж байсны гэрч баримт юм. Хэмжээ: амсар 16,3 см, өндөр 1,8 см, ёроол 7,4 см.

Холбогдох он цагийн асуудалд

Хар Хорумын туриас олдсон шаазан эдлэлийн эдгээр дарш зөвхөн Монгол гүрний нийслэлийн худалдаа, гар үйлдвэрлэлийн нэгээхэн үеийн хөгжлийн цар хүрээг

илтгэн харуулаад зогсохгүй мөн хотын амьдрал идэвхтэй өрнөж байсан түүхэн үечлэлийг тогтооход тус болох сонин хэрэглэгдэхүүн болно.

Юуны өмнө 1978 оны намар олдсон шаазангуудыг үзэхэд чен-хуа, лунцюань, рү зэрэг өнгө үзэмж, ур хийцээрээ хол ойрд нэр гарсан гоёмсог шаазангууд байна. Эдгээрийн хэлбэр хэмжээ, үйлдсэн арга барил, зураг хуарын онцлог зэргээс үзэхэд Монгол гүрний төв нийслэлийг Хар Хорумаас шилжүүлсэн XIII-XIV зууны Юань улсын үед холбогдох бололтой. Тухайлбал, ургамал болон амьтны дүрст хээтэй чен-хуа хэмээх хөх хуартай том тавгийг үзье. Цагаан цэнхэр өнгийн дэвсгэр дээр хар хөх өнгийн будгаар цэцэг навчит ургамлын дүрс, хөвж байгаа галуу, алхаж буй өрөвтас зэрэг жигүүртнийг урлан дүрслэхдээ үргэлжилсэн нарийн зураасаар бийр салгалгүй зурсан бөгөөд үе үе хүчтэй дарсан тул шаазангийн будаг зарим газраа гүн хар, зарим хэсэгтээ цайвар өнгөтэй үзэгдэнэ. Шаазангийн амсрыг зэрэгцээ шулуун зураас, ёроолын ханыг тухайн үед шаазангийн зураг чимэглэлд өргөн хэрэглэж байсан голдоо дугуй нүдтэй үүлэн хээ бүхий бадамлянхуа цэцгийн дэлбээ⁵ мэт дүрсээр хүрээлжээ. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны нутаг Хар хот болон бусад олон газраас олдсон Юань улсын үеийн хөх хуартай шаазангийн ёроолыг ингэж чимэглэсэн байх бөгөөд галуу нугас, дэглий өрөвтас мэт усны шувуудыг дүрсэлсэн үүнтэй ижил төрлийн шаазан эдлэл XIII-XIV зууны үед бүр Ойрхи Дорнодын бүс нутаг хүртэл нэвтэрч байжээ⁶. Түүнчлэн, уг тавагны овор их, хүнд бүдүүн бөгөөд хагарч эмтэрсэн газарт нь улаавтар шорооны өнгө гарсан зэргээс үзэхэд бүхий л төрх байдлаараа Юань улсын үеийн хөх хуартай шаазангийн хээ угалз, өнгө будгийн хослолын өвөрмөц онцлогийг илтгэн харуулна⁷.

Дээрх он цагийн баримжааг мөн даршнаас гарсан бусад селадон аяга, тавагнуудаас ч ажиглан харж болох юм. Жишээлбэл, бусад шаазан сав суулгыг бодвол илүү хүнд, хээ хуар нарийн, чанар сайтай лунцюань хэмээх төрөл байна. Юань улсын үед уг шаазангийн их биеийг тусгайлан бэлтгэсэн хэвэнд үйлдэж ихэвчлэн цэцгийн дэлбээ мэт дэрэвгэр амсартай хийдэг байжээ. Мөн гялалзсан шар ногоон өнгөтэй пааланг нь жигд, зузаан гүйлгэх тул будаг нь их биеийн хэвээр үйлдсэн хонхорт урсаж ороод тарвасны судал мэт тунаран харагддаг онцлогтой⁸. Үүнээс гадна дээрхи сав суулганы зүйлсийг удаан эдлэсэн шинжтэй бөгөөд зарим тавагны хагарлыг эвлүүлэн баривч хадаж байсан оромтой байгаа нь сонирхолтой юм. Уг баримтыг тухайн үеийн улс төр, эдийн засгийн түүхэн нөхцөл байдалтай холбож тайлбарлавал бас л XIII зууны хоёрдугаар хагаст Монгол гүрний улс төр, эдийн засгийн төвийг Хар Хорумаас шилжүүлсэн үйл явдалтай холбогдох бололтой.

Энэ нь манай ахмад археологич Х.Пэрлээ гуайн нэгэн өгүүлэлдээ бичсэнчлэн: "XIII-XIV зууны уулзвар үед, Монголын төмөр, төмөрлөгийн үйлдвэрийн төв болсон Хар Хорум хотыг цэргийн төв захиргаа өрнө тийш Чжэнхай балгасунд шилжиж монголын хан хөвгүүдийн хоорондын хямрал дайн (1260-аад 1300 хэдэн онд) үргэлжилж байсны хөнөөл уршгаар Монголын аж ахуй сүйрч, түүний төмрийн томхон үйлдвэр байтугай, нийт төмрийн дархны газрууд ч саарч, хөгжингүй үеэсээ буурангуй болсон бололтой. Хар Хорумын ба зарим суурин газрын оршин суугчид төмөр эдлэл байтугай, шавар сав суулга ч нэмэн үйлдвэрлэх тэнхэлгүй болсон байна. Тэр нь малтлагын давхрага дээд үеийн олдвор дотор зэс, гуулин баривч хадаастай шаазан,

⁵ Duncan Macintosh. Chinese Blue & White Porcelain. Second Edition, Hong Kong, 1987, pp.163

⁶ John Carswell. Kharakhoto and Resent Research in Inner Mongolia. Oriental Art. Vol. XLV, №4, New York city (1999/2000), pp.19-32

⁷ Жү Шү-пин. Хуучны шаазан эдлэлийг таних шинж тэмдэг. Шанхай, 1998, тал 42 (хятад хэлээр)

⁸ Margarit Medley. Yuan Porcelain and Stoneware. Pitman Publishing, 1974, pp. 63-81

шавар савны эвдэрхий цөөнгүй тохиолддогоос гэрчлэгдэж байна⁹ гэсэн дүгнэлттэй бас тохирно хэмээн бид бодож байна

Харин 1999 онд хотын төв хэсэгт Монгол-Германы Хар Хорум Экспедицийн явуулсан археологийн судалгаагаар илрүүлэн олсон даршны хувьд өмнө өгүүлсэн шаазан эдлэлийн даршнаас он цагийн хувьд харьцангуй эртнийх бөгөөд хотын аж ахуйн хөгжлийн хувьд ч арай өөр түвшинд байсан цаг үетэй холбогдох бололтой.

Хар Хорум хотод урьд өмнө явуулсан археологийн судалгааны явцад нийтдээ арав гаруй төрлийн шаазан илрэн олдсон нь голдуу Умард Сүн (960-1126), Ляо (907-1125), Цзинь (1115-1234), Өмнөд Сүн (1127-1279), Юань (1260-1368) улсын үед холбогдож байгаа юм¹⁰. Судалгаанаас үзэхэд, Хар Хорум хотод дорно дахины элдэв төрлийн гоёмсог шаазан эдлэлүүдийг олон орны худалдаачид харь газраас зөөвөрлөн авчирч худалдаж байсан төдийгүй зарим төрлийн паалантай савыг энд үйлдвэрлэж байсан ажээ¹¹. Үүний гэрч баримт нь 1948-1949 онд Монгол, Зөвлөлтийн археологичид Хар Хорум хотын төв хэсэгт буй гар үйлдвэр, худалдааны хорооллын ор үлдцийг малтах явцад шавар сав төдийгүй шаазан шатааж байсан зуухны үлдэгдлүүд илэрч олдсон явдал юм. Малтлагын үед эдгээр шавар, шаазан савнууд бүр пийшин дотроос олдож байснаас гадна түлэгдсэн, мушгирсан, цоорсон, хагалж орхисон үйлдвэрлэлийн хаягдлууд ч их хэмжээтэй гарсан байна. Энэ бүхнийг нутгийн урчууд болон монгол газарт олзлон аваачсан хятадууд хийж байсан бололтой гэж уг малтлагыг удирдсан Зөвлөлтийн нэрт эрдэмтэн С.В.Киселев бичсэн байдаг¹².

1999 онд илэрсэн шаазангийн даршнаас дин, цзюнь, юли-хун, рү, ин-тин хэмээх төрөлд багтах аяга сав, пял таваг, цомын зүйлүүд гарсан байна. Эдгээрийн дотор Хар Хорум хотын туриас хамгийн элбэг олддог нэгэн зүйл цагаан паалантай дин төрлийн аяга сав зонхилно. Ийм шаазангуудын дийлэнхийн нь бөөрцөгнөөс доошхи хэсгийг пааландалгүй орхижээ.

Хар Хорумаас олдож буй дин төрлийн савны паалан ерөнхийдөө шаргал туяатай бөгөөд гадаргуу дээрээ жижиг хар цэг толботой, шороо нь гадны хольц ихтэй байдгаас үзэхэд уг шаазангийн материалыг орон нутгийн түүхий эдээр бэлтгэж, ардын зууханд шатааж байсан бололтой. Мөн 1999 онд илэрсэн даршнаас гарсан нилээд аяга савны өнгөлгөө жигд бус, заримынх нь хэлбэр ч зөв бишийн дээр нэгээс бусдыг нь зориуд хагачиж орхисон тул үйлдвэрлэлийн гологдол ч юм уу гэмээр.

Харин Хар Хорум хотын малталтаас нилээд гардаг хөх өнгөтэй цзюнь хэмээх селадон шаазанг үзэхэд ахуйн хэрэгцээний аяга, тавагнаас авахуулаад олон янз хэлбэртэй хийж байсан нь мэдэгдэж байна. Энэ төрлийн шаазанг Тан улсын (618-906) үед анх үүдэн бүтээжээ. Үндсэн өнгө нь хөхөвтөр бөгөөд заримдаа паалангийн дор сацарсан гоёмсог улаан өнгөтэй ч байсан. Цзюнь шаазангийн урлал Сүн улсын үед ихэд мандаж, Юань улсын үед муудсан хэмээн судлаачид үздэг. Түүний гол бие

⁹ Х.Пэрлээ. Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын түүхийн асуудалд. *Studia Archeologica*. Tom. X, Fasc. 4, УБ., 1982, тал 62-63

¹⁰ Л.А.Евтюхова. Керамика Кара-Корума. - В кн: Древнемонгольские города. М., 1965. стр. 216-273

¹¹ У.Эрдэнэбат. Дундад зууны нүүдэлчдийн хэрэглэж байсан шаазан эдлэлийн тухай. *Studia Archeologica*. Tom. 19, Fasc.16, УБ., 1999, тал 135-145

¹² С.В.Киселев, Н.Я.Мерперт. Ремесленно-торговые кварталы Кара-Корума. - В кн: Древнемонгольские города. М., 1965. стр. 173-182

нь маш нарийн ширхэгтэй байхаас гадна гадаргууг өнгөлсөн пааланг зузаан түрхэх тул тэр нь шаазангийн ёроолд урсаж ирээд тунарсан байдаг онцлогтой¹³.

Хятадын эртний ваар, шаазангийн судалгааны ном зохиолд бичсэнээр Сүн улсын үед хийгдсэн "цзюнь" шаазангийн дундах нь нарийн, харин Юань улсынх нилээд зузаавтар байдаг ажээ. Манай хэрэглэгдэхүүнд буй цзюнь тавгийг үзвэл паалан нь гоёмсог хөх өнгөтэй бөгөөд гол бие нь нимгэн байгаа тул түүнийг Сүн улсын үеийн хэв намбатай гэж тооцож болохоор юм.

Манай улсын нутагт байгаа эртний хот балгасын үлдэгдлээс археологийн судалгааны явцад илрэн олдож буй цзюнь мэтийн шаазан эдлэлийг дундад зууны үеийн нүүдэлчид ахуй амьдралдаа хэрэглэж байсан тухай сонирхолтой мэдээ Монголын түүхийн зарим сурвалжид тохиолдож байна. Тухайлбал, "Монголын Нууц Товчоо"-ны 179-р зүйлд: Чингис хааны Жамуха андадаа хэлүүлсэн үгэнд "Qan ecige-dece min-u üzen jadazu qayacayulba ci. Urida bosuysan bidan-u Qan ecige-jin kökө zün uyuqu bülege. Na-da urida boscu uydarun naidaba-ze ci. Edöge Qan ecige-jin kökө zün baradqun kedüi-ze qoroqun ta"¹⁴ "хэмээн тэмдэглэхдээ, хоёр ч удаа хан эцгийн "kökө zün" хэмээх аяга савны тухай дурдсан байдаг билээ.

"Монголын Нууц Товчоо"-г судалсан ихэнх эрдэмтэд энэхүү "zün" хэмээх үгийг түүний хятад хадмалын утгыг баримтлан "том аяга", "цом, хундага", "их хувин, их суулга, их ган", "хөхүүр", "хул аяга" гэх зэргээр хөрвүүлэхийг оролдсон бөгөөд зарим судлаачид энэ бол монгол үгийг өөр хэлний үгтэй андуурсан хэрэг бололтой хэмээн тайлбарласан ч үзэгдэнэ¹⁵.

Харин бидний санавал, энэхүү "kökө zün" гэдэг үгийн "zün" хэмээхийг заавал монголоор орчуулах шаардлагагүй мэт бөгөөд энэ үг бол ердөө л дундад зууны үед нүүдэлчдийн ахуй амьдралдаа өргөн хэрэглэж байсан нэгэн зүйлийн хөх өнгийн паалантай "цзюнь" хэмээх шаазангийн нэр бололтой.

Бидний 1999 онд илрүүлэн олсон даршнаас илэрч гарсан өөр нэг сонирхолтой олдвор бол ногоон паалантай жижиг селадон хундага юм. Үүний ерөнхий хэлбэр дүрсийг харахад манай улсын дорнод нутгаар голчлон тархсан XIII-XIV зууны Монгол гүрний үеийн хүн чулуун хөшөөдийн гарт цээжин тушаа нь бариулан дүрсэлдэг хундага савыг эрхгүй санагдуулна. Хүн чулуу бол нас нөгчсөн өвөг дээдсийн онго дүрс тул уй тайлах ёслолд өөрийг нь биечлэн оролцуулж тайлгын идээ унднаас адилхан хүртээж байгаа санааг агуулж гарт нь хундага сав бариулж дүрсэлдэг уламжлалтай бөгөөд судлаачид зарим хөшөөнд дүрсэлсэн урт иштэй, цөмбөгөр бөөртэй цом маягийн савыг эртний судлалын цөөн олдворт түшиглэж шавар болон алт, мөнгөн сав хэмээн үзэж ирсэн. Гэтэл бидний гарт байгаа шинэ хэрэглэгдэхүүнээс үзэхэд хүн чулуунд дүрсэлдэг хундага маягийн сав бол заавал шавар болон хүрэл, алт, мөнгөн цом бус бас шаазан ч байж болохыг үгүйсгэх аргагүй болж байна.

Хар Хорумаас 1999 оны малтлагаар илэрсэн шаазангийн даршинд бас улаан будагтай юли-хун хэмээх таваг байсан билээ. Энэ шаазангийн зураг чимэглэлд дүрсэлсэн хос загас бол X-XII зууны үеийн урлагийн бүтээлд ихэд түгэн дэлгэрч

¹³ He Li. Chinese Ceramics. The New Standart Guide. From the Asian Art Museum of San Francisco. Thames & Hudson Ltd., 1996

¹⁴ B.Sumyabaatar. The Secret History of the Mongols. Transcription. Editor L.Manlajav, Ts.Shagdarsuren. Ulaanbaatar, 1990, pp. 416, 417

¹⁵ Монголын Нууц Товчоон. Худам (язгуур эртний) монгол бичгээр монгол бичиг, утга судлалын үүднээс Шанжмятавын Гаадамбын төсөөлөн нягтлаж сэргээсэн сийрүүлэг эх, тайлбар. УБ., 1990, тал 352

байсан сэдэв ажээ. Дорно дахины орнуудын ёс уламжлалд хос загасыг эв нэгдэл, сонор соргог, өнөржин үржихийн бэлгэдэл хэмээн үзэхийн зэрэгцээ ялангуяа аяга шаазан дээр дүрслэх нь "идээд баршгүй хоолтой явна" хэмээсэн далд ёгт утгыг илэрхийлж байв. Түүнчлэн энэ даршнаас X-XIII зууны үеийн хэв маягтай, цэгээн өнгөт, маш нимгэн голтой ин-тин хэмээх шаазан, гялалзсан ногоон өнгийн паалантай рү хэмээх бүтэн селадон аяга олдсон юм. Эдгээр сав суулгын хэлбэр загвар, зураг чимэглэлийн онцлог зэргээс үзвэл уг дарш лавтайяа XIII зууны эхэн хагасаас урагших цаг үед холбогдохгүй байгаа даа хэмээн бодоход хүргэнэ.

Энэ нь Хар Хорумын тухай 700 жилийн дотор тэмдэглэсэн, бичсэн бичгийн мэдээг манай оронд явуулсан эртний судлалын шинжилгээний мэдээтэй харьцуулан үзэхэд, Хар Хорумыг XIII зуунаас бүр өмнө байгуулсан нь үнэнтэй байна хэмээсэн зарим эрдэмтдийн таамаглалтай нийлэлцэнэ¹⁶.

Бидний харьцуулсан судалгаагаар гаргаж авсан дээрх он цагийн баримжаа ерөнхийдөө зөв зүйтэй болохыг байгалийн шинжлэх ухааны шинжилгээний дүн нотолж өгч байна. Хар Хорум хотын гудамжны уулзварын барилгын малталтаас 1999 оны судалгаагаар илэрсэн шаазан эдлэлийн даршны үлдэгдэл бүхий нүхнээс гарсан амьтны яснаас дээж авч ХБНГУ-ын Эрланген-Нюрнбергийн Их Сургуулийн Физикийн Хүрээлэнгийн лабораторид илгээж радиокарбоны аргаар он цаг тогтоох шинжилгээ хийлгэхэд дараах дүн гарсан юм. Үүнийг хойно толилуулбал: дээжийн дугаар: Kar.2/132, лабораторийн дугаар: Erl-3308, дээжийн хэмжигдэхүүн: 974±40 радиокарбон жил, калибрийн тогтмол хэмжигдэхүүний наслал: 864 BP±78 жил, 68,3 % магадлалтай (1 Sigma): МЭ 1017-1052 он, МЭ 1085-1119 он, МЭ 1137-1158 он, 95,4 % магадлалтай (2 Sigma): МЭ 1008-1165 он хэмээн дурсгалын үнэмлэхүй он цагийг тогтоожээ (15-р зураг).

1346 онд Хар Хорумд босгосон нэгэн гэрэлт хөшөөний бичигт <<[Cinggis qan yeke or-a sayuysan arban tabuduyar on] ging luu [jil-dür] Qorum-a sayuu balayasun orosiyluysan ajuu¹⁷ >> хэмээн тэмдэглэсэнээс үндэслэн монголчууд Чингис хааны зарлигаар Хар Хорум хотыг 1220-1221 оны орчим үндэслэн байгуулсан хэмээн үздэг билээ. Гэтэл дээрх радиокарбоны мэдээнд үндэслэвэл Хар Хорум хотын төв хэсгээс 1999 оны археологийн судалгаагаар илрүүлсэн шаазан эдлэлийн дарш уг хотыг үндэслэн байгуулсан тухай дээрх бичгийн сурвалжид дурдсан он цагаас бараг 100 шахам жилийн өмнө буюу XI-XII зууны үед холбогдох болж байна.

Энэ бол Монголын хот суурины судалгаанд урьд өмнө төдийлөн хэрэглэж байгаагүй байгалийн шинжлэх ухааны аргаар хөрсний соёлт давхрагын үечлэлийг нарийвчлан тогтоож эхэлсэн дэвшилтэт алхам бөгөөд цаашид бид дээрх үнэмлэхүй он цагийг хотын хэд хэдэн хэсэгт лавшруулан шалгах болно.

Summary


Two hoards of chinese ceramics are discovered from ancient Karakorum city which introduced in this article. We are trying to define 6 ceramics which found in 1978 and 10 ceramics which found in 1999 from archaeological point of view and to determine their dates. By the feature of style and decoration, the hoard which found in 1978 is dated back to the second half of 13th century. Another hoard which discovered in 1999 is proved that it may date before 13th century by the radiocarbonic test.


¹⁶ Х.Пэрлээ. Монгол Ард Улсын эрт, дундад үеийн хот суурины товчоон. УБ., 1961, тал 73

¹⁷ F.W.Cleaves. The Sino-Mongolian Inscription of 1346. Harvard Journal of Asiatic Studies. Vol.15, Cambridge, 1952, pp. 69




1-р зурар







2-р зураг







3-р зураг







4-р зураг







5-р зураг







6-р зураг







7-р зураг







8-р зураг







9-р зураг







10-р зураг






11-р зураг






12-р зураг





13-р зураг





14-р зураг

